

ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан Уул аймгийн "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/23/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан Уул аймаг, Дархан сум 2024 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан.....	12
4.1. Ерөнхий зүйл	12
4.2. Материаллаг байдал	13
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
Залруулга	15
5.1 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь тайлант онд 1,120,524.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 587,126.2 мянган төгрөгийн зардал гарган 533,397.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо, аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 210 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 98.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
		/төгрөгөөр/	
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	236,573,057.10	751,659,569.51
1.1.2	Дансны авлага	10,779,035.51	20,875,502.54
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	157,740.12	6,961,023.37
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	5,579,823.25	7,052,550.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	253,089,655.98	786,548,645.94
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	59,669,737.37	74,278,473.01
1.2.2	Биет бус хөрөнгө	460,000.00	2,386,363.66
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	60,129,737.37	76,664,836.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	313,219,393.35	863,213,482.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	40,295,405.32	70,392,239.26
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	121,506,190.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	40,295,405.32	191,898,429.26
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	40,295,405.32	191,898,429.26
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	18,193,545.00	18,193,545.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.3	Хувьцаат өр төлбөр		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,458,827.00	21,458,827.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	233,271,616.03	631,662,681.35
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	272,923,988.03	671,315,053.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	313,219,393.35	863,213,482.61

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	729,193,797.73	1,120,524,144.87
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	729,193,797.73	1,120,524,144.87
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	7,169,070.91
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	8,118,105.00	22,100,806.57
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	497,392,061.40	559,585,286.05
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	239,919,841.33	590,208,736.30
19	Орлогын татварын зардал	23,180,173.63	56,810,792.98
20	Татварын дараах ашиг (алдагдал)	216,739,667.70	533,397,943.32
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	216,739,667.70	533,397,943.32
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	216,739,667.70	533,397,943.32
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	181,531,948.33	221,184,320.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	181,531,948.33	221,184,320.33
6	Зарласан ногдол ашиг	-	-	(165,000,000.00)	(165,000,000.00)
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	216,739,667.70	216,739,667.70
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	233,271,616.03	272,923,988.03
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	233,271,616.03	272,923,988.03
14	Зарласан ногдол ашиг	-	-	(135,006,878.00)	(135,006,878.00)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	533,397,943.32	533,397,943.32
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	631,662,681.35	671,315,053.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	798,178,751.50	1,244,907,518.93
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	790,289,857.50	1,223,216,712.36
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	84,889.00	778,650.30
1.1.4	Буцаан авсан албан татвар	7,728,105.00	20,862,156.27
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	75,900.00	50,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	574,903,296.64	697,560,177.43
1.2.1	Ажилагсад төлсөн	135,112,995.00	186,548,582.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	37,760,371.68	53,407,697.96

1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,517,400.00	20,929,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,672,091.81	8,527,085.53
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,012,700.00	7,759,650.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	76,251,830.15	151,311,477.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	490,900.00	516,200.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	290,085,008.00	268,560,484.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	223,275,454.86	547,347,341.50
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	7,169,070.91
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	7,169,070.91
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,144,800.00	39,429,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	47,144,800.00	35,929,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	3,500,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(47,144,800.00)	(32,260,829.09)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	169,951,682.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	169,951,682.00	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(169,951,682.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,178,972.86	515,086,512.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	230,394,084.24	236,573,057.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	236,573,057.10	751,659,569.51

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	737,311,902.73	570,000,000.00	1,149,794,022.35	579,794,022.35	201.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	729,193,797.73	570,000,000.00	1,120,524,144.87	550,524,144.87	196.6
	Бусад орлого	8,118,105.00	0.00	29,269,877.48	29,269,877.48	0.00
3	Нийт зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00

	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	0.00
	б) Ерөнхий удирдлагын зардал	520,572,235.03	532,753,000.00	616,396,079.03	83,643,079.03	115.700161
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Цэвэр ашиг, алдагдал	216,739,667.70	37,247,000.00	533,397,943.32	496,150,943.32	1432.05612

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь “Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дүрэмд Дархан-уул аймаг болон сумдад хэрэгжүүлж буй улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, гадаадын болон зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй барилга угсралт, авто зам, инженерийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Барилга байгууламжийн төлөв байдлыг үнэлэх, бат бөх чанарыг тооцоолох, норм дүрмийн шаардлагыг хангах
- Барилгыг зураг төслийн дагуу угсарч барих ажлыг удирдан зохион байгуулах, инженерийн хяналт тавих
- Материал, тоног төхөөрөмж, ажиллах хүчний тоо хэмжээ, үнэ өртгийг тооцоолон төслийн бодит хэрэгжих боломжийг тооцоолох
- Барилга угсралтын явц, төлөвлөгөөний биелэлт болон материал бүтээц, эдлэхүүний чанар, хийцэд зураг, төсөв, барилгын норм, дүрэм стандарт, техникийн нөхцөлийн дагуу хяналт тавих
- Барилга угсралтын явцад үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэх, гарсан доголдлын шалтгааныг судалж тодорхойлох, сэргийлэх арга хэмжээ авах
- Барилгын материал бүтээц, эдлэхүүнийг шаардлагатай тохиолдолд сайжруулах солих, хийцийн шийдэлд өөрчлөлт оруулах
- Байгууллагын удирдлагыг мэргэжлийн түвшинд барилга угсралтын явц болон төлөвлөгөө тайлангаар хангах
- Барьж дуусгасан барилга байгууламжийг техникийн комисст хүлээлгэн өгөх, холбогдох бичиг баримтыг бэлтгэх, гүйцэтгэлийн үе шатны хуваарийн дагуу хянан баталгаажуулах чиг үүрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдсэн,
- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Авто замын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж болон байгууллагын дүрмийг удирдлага болгоно.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын мөрдөж буй “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 549,994.1 мянган төгрөгөөр буюу 75.59 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	236,573.10	751,659.60	515,086.50
Авлага	10,936.70	27,836.50	16,899.80
Бараа материал	5,579.80	7,052.50	1,472.70
Үндсэн хөрөнгө	60,129.70	76,664.80	16,535.10
Нийт хөрөнгө	313,219.30	863,213.40	549,994.10
Өр төлбөр	40,295.40	191,898.40	151,603.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	272,923.90	671,315.00	398,391.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	313,219.30	863,213.40	549,994.10

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 751,659.6 мянган төгрөг болж 515,086.5 мянган төгрөгөөр өссөн нь 1,252,076.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 736,990.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 27,836.5 мянган төгрөг болж 16,899.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны хөрөнгө оруулалтын гэрээт ажлын авлага 17,416.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7,416.2 мянган төгрөгийн авлага төлөгдсөн, НӨАТ-ын авлага 5,797.6 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 1,005.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,052.5 мянган төгрөг болж 1,472.7 мянган төгрөгөөр өссөн нь 27,066.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 25,593.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,535.1 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 19,800.0 мянган төгрөгийн автомашин худалдан авсан, 14,663.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,181.8 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авч, байнгын ашиглалтад хүлээн авсан, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар сарын 24-ны өдрийн 01-А/333 тоот захирамжаар тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3,690.2 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгслийг акталж данснаас хассан, тайлант онд 21,100.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 191,898.4 мянган төгрөг болж өссөн нь 2023 оны ноогдол ашиг өглөг 121,506.2 мянган төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын татварын өглөг 56,863.2 мянган төгрөг, бусад татварын өглөг 13,500.7 мянган төгрөг болж тус тус өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 398,391.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг орон нутгийн өмчийн газар болон аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс хянаж, Засаг дарга баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 570,000.0 мянган төгрөгөөр, нийт үйл ажиллагааны зардлыг 532,753.0 мянган төгрөгөөр, 37,247.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 6 зорилтын хүрээнд 210 төсөл, арга хэмжээнээс 1,120,524.1 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 29,269.9 мянган төгрөг, нийт 1,149,794.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 616,396.1 мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,149,794.0 мянган төгрөг болж төлөвлөгөөг 579,794.0 мянган төгрөг буюу 201.7 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 533,397.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 496,150.9 мянган төгрөгөөр өссөн нь эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнд хяналт тавьсантай холбоотой байна.

Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчийн тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит газрын дүрмийн 5 дахь бүлгийн 5.9 дэх “Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас 25 хүртэл хувийг ногдол ашиг хэлбэрээр аймгийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтын дагуу 121,506.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцоолон санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлыг харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд байгууллагын татварын тодорхойлолтоор татварын төрөл бүрээр илүү төлөлттэй байгааг хянаж, татварын байгууллагатай тооцоо хийж үлдэгдлийг залруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлын дүн 532,753.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,655.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Даргын 2023 оны А/53 тоот тушаалаар тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй 731.5 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны зорилго, зорилтыг хангах төлөвлөгөө хөтөлбөр гарган батлуулж ажиллах.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 17,618.2 мянган төгрөгийн 6 шийдвэр мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн байршуулж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8,777.3 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	8,777.3	1	8,777.3	100.0
Нийт дүн	1	8,777.3	1	8,777.3	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитын явцад дараах алдааг залруулсан. Үүнд:

Монголын татварын албаны “*Байгууллагын татварын тодорхойлолт*”-оор татварын төрөл тус бүрээр илүү төлөлттэй гэсэн боловч санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй, татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй санхүүгийн тайланг 6,961.0 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар нийт 1,516.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,516.8 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Даргын 2023 оны А/117 тоот тушаалаар томилсон тооллогын комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оруулсан байгаа нь хяналт тавих боломжгүй байдлыг үүсгэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д “*Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх үүрэгтэй*”, 72.5.1-д “*Тооллогын комисс нь тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах үүрэгтэй*” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгө хариуцах, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах ажилтныг тооллогын комисст оруулахгүй байх, төрийн болон орон нутгийн өмчид хяналт тавих боломжоор хангаж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Илрүүлэлт: Даргын 2023 оны А/04 тоот тушаалаар “*2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлах тухай*” тушаалын хавсралтын 46-д “*Харилцахын баримтыг 10 жил*”, 49-50-д “*Байгууллагын НД шимтгэлийн тайлан, ажилтнуудын нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, албан хаагчдын цалингийн картыг 70 жил*” хадгалахаар заасан боловч харилцахын баримтанд цалингийн баримтыг үдсэн байна. Энэ нь Архивын тухай хууль 44 дүгээр зүйлийн 44.2-т “*Байгууллага хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг он, сар, өдөр, дугаар, ач холбогдол, агуулга, сэдэв, хадгалах хугацаа зэрэг үндсэн шинжийг харгалзан ангилан төрөлжүүлнэ*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Архивын тухай хууль болон Газрын даргын тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажлын байрны тодорхойлолтын "1-р зорилтын хүрээнд архивын үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөх..., 2, 3-р зорилтуудын дагуу байгууллагын үл хөдлөх биет хөрөнгө, материалын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тооллого тогтмол хийх... гэх мэт" үндсэн ажил үүргээ гүйцэтгэсэн ажилтанд орон тоо, цалингийн санд батлагдаагүй "Архив, нярав"-ын албан тушаалыг хавсруулан гүйцэтгүүлэх тухай 2023 оны Б/35 тоот даргын тушаалаар 1,516.8 мянган төгрөгийн цалин тооцож олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "*Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохыг хориглоно*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн ажлын орон тоо нэн шаардлагатай бол бүтэц орон тоонд өөрчлөлт оруулан холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах, цаашид алдааг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татварын өр, авлага зөрүүтэй тайлагнасан.	1	6,961.0					1	6,961.0				
	1	6,961.0	0	0	0	0	1	6,961.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

Тооллогын хяналт болон комисст тавих боломжгүй байдлыг үүсгэсэн.	1	0.0					1	0.0			
2023 оны хэтлэх хэргийн нэрийн жагсаалт батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	1	0.0					1	0.0			
Ажилтанд орон тоо, цалингийн санд батлагдаагүй "Архив, нярав"-ын албан тушаалд хавсруулан гүйцэтгүүлэх тушаалаар цалин тооцож олгосон байна.	1	1,516.8					1	1,516.8			
	3	1,516.8					1	1,516.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 17,618.2 мянган төгрөгийн 6 шийдвэр мэдээлээгүй байна. төгрөгийн 6 шийдвэр тус тус мэдээлээгүй байна.	1	17,618.2					1	17,618.2
Дүн	1	16,618.2					1	16,618.2
Хэмнэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Даргын 2023 оны А/53 тоот тушаалаар тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй 731.5 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан.	1	731.5					1	731.5
Дүн								
Нийт дүн	2	18,349.7					2	18,349.7